



## АМЬДРАЛЫНХАА ТУРШИД ХИЧЭЭХ НЬ

### Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Даллин Х.Өүкс

СБС-ийн Залуу Насанд Хүрэгчдэд Зориулсан Галын Дэргэдэх Ярилцлага  
2005 оны Тавдугаар сарын 1 • Оукланд, Калифорни

Ах, эгч нар минь, би өөрийн талархлаа найрал дууныханд сүнслэг урам өгсөн, сэтгэл хөдөлгөм хөгжмийнх нь төлөө илэрхийлж байна. Мөн Ерөнхийлөгч Стивен Эдгрений танилцуулгад баярлалаа.

Би Оукландад байгаадаа баяртай байна. Энд байгаа болон бусад газруудад цуглараад буй та бүхэнд ирсэнд тань талархлаа илэрхийлмээр байна.

Миний бие 18–30 насныханд хандан ярьж байгаадаа их баяртай байна. Учир нь хамгийн бага охин маань болон 28 ач нарын маань 15 нь энэ насныханд багтдаг юм. Иймд би энэ насныхны талаар онцгойлон сонирхож байдаг билээ.

#### Өдөр Бүр Сургаалаар Амьдар

Та нарт хандан ярьснаар би ирээдүйн төлөө ярьж байна. Та нар бол бизнес, боловсрол, шинжлэх ухаан, хот, муж, үндэстний болоод Сүмийн ирээдүйн удирдагчид юм. Эдгээрээс илүүтэй та нар бол Сүмийн гэр бүлүүдийн удирдагчид.

Энэ оройд бэлтгэхдээ би СБС-ийн залуу насанд хүрэгчдэд зориулсан галын дэргэдэх ярилцлагад өгөгдсөн сүүлийн яриаг судалсан юм. Энэ нь Хоёрдугаар сарын 6-ны ням гараг байсан бөгөөд цуглаан нь Бригам Янгийн Их Сургуулийн Марриот төвд болсон билээ. Харин яригч нь Арванхоёрын Чуулганы Ахлагч Рассел М.Нелсон байсан. Яриа нь гэгээрэм болоод сэтгэл хөдөлгөм байлаа.

Ахлагч Нелсон та нарыг “өөрсдийгөө одоо байгаагаараа биш, харин 50 жилийн дараа ямар байж болохоор төсөөл” хэмээн уриалсныг та нар санаж байгаа. “Одооноос 50 жилийн дараа гэхэд та нар ямар хүмүүс болсон баймаар байна?” гэж тэр асуусан. Дараа нь тэрээр “Итгэл ба Гэр бүл”-ийн талаар нэгэн агуу захиасыг өгсөн. Тэрээр өөрийнхөө болон хайрт хамтрагч Данцелийнхаа амьдралын талаар өгүүлж боловсрол олохын тулд удаан зүтгэсэн талаараа ярьсан. Бурханы хаант улсыг эхэнд тавин хамтын амьдралдаа гаргасан шийдвэрүүдийнхээ талаар бас ярьсан. Итгэл нь “[тэдний] гэр бүлийн амьдралын алтан гадас” хэмээн тэрээр хэлсэн билээ. Түүнчлэн анагаахын сургууль төгсөөд 12 гаруй

жилийн дараа л орлого олж эхэлснээ хуваалцсан. Тэр үед тэд аль хэдий нь 5 хүүхэдтэй болсон байж. Нелсон эмчийн мэргэжлээ эзэмших удаан хугацааны явцад тэдний гэр бүлээрээ урагшлахын тулд гаргасан итгэлийн чармайлт, золиослолыг та нар төсөөлж чадах байх. (*Итгэл ба Гэр бүл* үз [СБС-ийн залуу насанд хүрэгчдэд зориулсан галын дэргэдэх ярилцлага 2005 оны Хоёрдугаар сарын 6], 1–2.)

Хэрэв та нар Ахлагч Нелсоны 4 сарын чуулганд өгсөн гайхамшигт яриаг санаж байгаа бол өнгөрсөн 2 сарын 6-ны СБС-ийн яриаг уншаад миний сэтгэл яагаад хөдөлснийг ойлгох байх. Тэрхүү яриандаа Нелсон ах өөрийн хайрт хамтрагчдаа зүйрлэшгүй хүндэтгэл магтаалыг үзүүлсэн ба үүнээс ердөө 6 хоногийн дараа эхнэр нь гэнэтийн байдлаар нас барсан юм. Үнэхээр Ахлагч Нелсоны заасанчлан, амьдралд санаандгүй явдлууд тохиолддог бөгөөд бидний хувьд 50 жилийн дараа ямар хүмүүс болох талаараа бодоод зогсохгүй, мөн түүнчлэн гэнэт тэнгэрийн гэртээ очихоор дуудагдвал бэлэн байхаар өдөр тутмын амьдралаа өнгөрөөх нь чухал юм.

#### “Тэдгээрийг Өөрсдөө Үйлдэхэд Анхаарагтун”

Өнгөрсөн долоо хоногт би Арванхоёр Чуулгын нэгэн гишүүнтэй өнгөрсөн дөрвөн сарын чуулганд өгсөн яриануудынхаа талаар бусдаас хүлээн авсан сэтгэгдлүүдийн тухай ярьж байсан юм. “Таны яриа үнэхээр таалагдсан шүү” гэж найзад маань хэн нэгэн хэлж л дээ. Энэ нь бид хоёрын сонсохыг хүсдэг үгс бишээ гэдэг дээр бид хоёрын санаа нийлж байлаа. “Би тэр яриаг таалагдуулах гэж өгөөгүй юм. Намайг зугаацуулагч гэж бодсон юм байхдаа?” гэж тэр хэлж билээ. Чуулгын маань өөр нэг гишүүн ярианд маань нэмэрлэж: “Энэ чинь надад нэгэн сайн сургаал дэлгэрүүлэгчийн түүхийг санагдуулж байна. Нэг сонсогч нь түүнд ‘Таны өнөөдрийн номлол надад үнэхээр таалагдлаа’ гэхэд тэр, ‘Тийм бол та намайг ойлгосонгүй’ гэжээ.”

Энэ дөрөвдүгээр сарын чуулганаар та нар намайг порнографийн талаар ярьсныг санаж байгаа байх. Хэн ч миний яриаг “таалагдсан” гэж хэлээгүй, бүр

нэг ч хүн. Үнэндээ үүнд надад ч таалагдах зүйл огт байгаагүй юм.

Их Эзэний ажлыг урагшлуулахын төлөө Сүнсний нөлөөн дор бэлтгэгдэн, Ерөнхий Эрх Мэдэлтнүүдээр, Ерөнхий чуулган дээр өгөгддөг яриа нь таалагдуулахын төлөө бус юм гэдэг зарчмыг заахын тулд саяхан болсон яриануудын талаар би хэллээ. Урамшуулахын төлөө, гэгээрүүлэхийн төлөө, сорихын төлөө, эсвэл засаж залруулахын төлөө тэдгээр нь өгөгддөг. Энэ нь Их Эзэний Сүнсний нөлөөн дор хүлээн авагдах учиртай ба сонсогч нь суралцаж энэ талаар юу хийх ёстойгоо Ариун Сүнснээс хүлээн авдаг.

Бэнжамин хаан энэ зарчмыг ойлгосон ба үүнийг тайлбарласан юм. Мозаягийн эхний хэдэн бүлэгт агуулагддаг түүний агуу яриа ийн эхэлдэг:

“Ах дүүс минь, энэ өдөр миний та нарт ярих тэр үгсийг маань сонсож чадахын тул, та бүгд өөрсдөө чуулжээ; өөрөөр хэлбэл та нарыг нааш ирж миний ярих тэр үгсийг тохуурхахыг би зарлиг болгоогүй, харин та нар намайг сонсогтун, мөн та нар сонсож болохын тулд сонороо дэлгэгтүн, мөн ойлгож болохын тул зүрхээ нээгтүн . . .” (Мозая 2:9).

Энэхүү бошиглогч-хааны зааснаар, бид Их Эзэний зарлагын үгсийг сонсохоор ирэхдээ “үгийг нь тохуурхахаар” бус юм. Үүнээс гадна, сонсож болохын тулд сонороо дэлгэн, ойлгож болохын тулд зүрхээ нээх нь бидний үүрэг билээ. Түүнчлэн бидний ойлгохоор эрэлхийлэх зүйл нь тэрхүү захиасын дагуу юу хийх вэ гэдэг нь байх учиртай. Бэнжамин хаан ингэж л хэлж байсан гэж би итгэлтэй байна, учир нь тэрээр цааш нь хэлэхдээ: “мөн эдүгээ, хэрэв та нар эдгээр бүх зүйлд итгэвэл тэдгээрийг өөрсдөө үйлдэхэд анхаарагтун” (Мозая 4:10). Энэхүү Хишиг өдөр намайг та нарт ярих үед энэ зарчмыг санаж байгаарай.

### “Амьдралын Туршид Тууштай, Тогтмолоор Хичээх нь”

Би энэ яриагаа “Амьдралынхаа Туршид Хичээх нь” гэж нэрлэсэн юм. Энэхүү нэрийг 1952, 1956 онуудад АНУ-ын ерөнхийлөгчийн төлөө Демократ намаас нэр дэвшиж байсан, Иллиной мужийн захирагч асан Адлай И.Стивенсоны хэлсэн үгнээс иш татсан юм. Тэрээр сайн хүн байсан ба Двайт Д.Айзнхауэр гэгч ихэд нэртэй өрсөлдөгч байгаагүйсэн бол тэр ерөнхийлөгч болох байсан байх.

Америкийн сайн үйлсийн төлөөх нэгэн байгууллагын хурал дээр Стивенсон эх оронч үзлийн талаар дараах

мэргэн үгийг хэлжээ. Тэрээр хэлэхдээ, бидэнд хэрэгтэй зүйл нь “сэтгэл хөдөллөөр гэнэтийн хэтрүүлсэн зүтгэл биш, харин амьдралынхаа туршид тууштай, тогтмолоор хичээх” нь юм гэжээ. (Илтгэл 1952 оны 8-р сарын 27-нд тавигдсан, John Bartlett-ий эмхэтгэл, *Familiar Quotations-ий*, 13-р хэвлэл. [1955], 986). Энэ нь надад их таалагддаг—“сэтгэл хөдөллөөр гэнэтийн хэтрүүлсэн зүтгэл биш, харин амьдралынхаа туршид тууштай, тогтмолоор хичээх.” Энэхүү эх оронч байдлын тухай хэлэгдсэн үгнээс сургаалийг хэрхэн дагахыгаа суралцаж.

Зарин хүмүүс сургаалийг дагахдаа “сэтгэл хөдөллөөр гэнэтийн хэтрүүлсэн зүтгэл”-ийг гаргаад, дараа нь удаан хугацаагаар больж, эсвэл тасалданги, тогтмол бишээр ханддаг. Бид сургаалийг дагахдаа “амьдралынхаа туршид тууштай, тогтмолоор хичээх” хэрэгтэй юм.

Тэгвэл зарилгуудыг дагахдаа, гэрээнүүдээ сахихдаа болон Их Эзэнд үйлчлэхдээ “амьдралынхаа туршид тууштай, тогтмолоор хичээх” гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь цагийнхаа 100 хувьд, 100 хувь Хожмын Үеийн Гэгээнтэн байна гэсэн үг юм. Судрын үгсээр, энэ нь Бэнжамин хааны өөрийн хүмүүстээ: “Христ Төгс Хүчит Их Эзэн Бурхан та нарыг өөрийнх нь байлгахаар лацдаж болохын тул, би та нарыг хичээнгүй мөн гуйвшгүй байж, үргэлж сайн үйлүүдээр бялхаасай хэмээнэ” (Мозая 5:15) гэж хэлсэн зааврыг дагана гэсэн үг юм. Энэ нь эцэг Лихайгийн эргэлзэж буй хүүдээ: “Ай Их Эзэний зарлигуудыг дагахдаа чи энэ хөндий мэт тууштай бас гуйвшгүй бас хөдөлшгүй байгаасай!” (1 Нифай 2:10) гэсэн нь бас мөн.

“Амьдралынхаа туршид хичээх” нь нэгэнийг тууштай болон тогтмол, гуйвшгүй болон хөдөлшгүй байхыг шаарддаг. Өөрсдийнхөө хийсэн гэрээнүүдийг сахиж, удирдагч нараа, Их Эзэний зарц нарын өгсөн заавруудыг тууштай дагаснаар бид төлөөлөгч Паулын бичсэнчлэн, “цаашид хүүхэд байхаа больж, давалгаанд энд тэнд шидэгдэн аливаа номлолын салхинд туугдахгүй” байж болно. (Ефес 4:14) Энэ нь бидний жишиг ба зорилго бөгөөд гуйвшгүй байдлын жишиг нь биднийг аливаа хэтрүүлэгээс зайлсхийхийг шаарддаг. Гүйцэтгэл маань хэт бишрэгчийн үе үеийн 120 хувь бус, үнэнч зарцын тууштай 100 хувь байх ёстой.

Олон жилийн өмнө Бригам Янгийн Их Сургуульд байсан нэгэн эрхэм багш маань хэт бишрэгч гэдгийг ингэж тодорхойлсон юм: “Хэт бишрэгч гэдэг нь өөрийн зорилгыг мартаад, гэхдээ түүндээ хүрэх гэж 2 дахин чармайж байгаа нэгэн юм.” Энэ тодорхойлолт нь миний амьдралд нэгэн сайн удирдамж

байсаар ирсэн ба одоо үүнийг би та нарт санал болгож байна. Өөрийн хичээл зүтгэлийг үе үеийн хэтрүүлгээр, эсвэл “танаас илүү ариун” хэмээсэн бусад баталгаагаар нотлохыг бүү оролдоорой. Бид аравны нэгийг төлдөг. Аравны нэг нь 8 хувь, ялангуяа тасалданги эсвэл гэнэтийн хэтрүүлсэн 12 хувь бус харин байнгын 10 хувь байх учиртай гэдгийг бид мэднэ.

Энэ нь надад БЯИС-ийн ерөнхийлөгч байхад Ерөнхийлөгч Харолд Б.Лий санааг нь зовоосон зүйлийнхээ талаар надад хэлж байсныг санагдуулж байна. Провогийн Ариун Сүмийг онцгойлон адислахын өмнөхөн, ойрхон Ариун Сүмтэй болсноор БЯИС-ийн зарим оюутнууд Ариун Сүмд ойр ойрхон орох гээд хичээлээ орхигдуулах вий хэмээн тэрээр санаа зовж байгаагаар надад хэлсэн юм. Оюутан байх үеийнхээ гол зорилго болох хичээлүүдээ орхигдуулахгүйн тулд Ариун Сүмийн үйлчлэл мэт нандин зүйлс ч мэргэн ухаан, эмх замбараанд хийгдэх хэрэгтэйн чухлыг оюутнууд ойлгосон эсэхт анхаарал хандуул хэмээн тэрээр намайг БЯИС-ийн гадасны ерөнхийлөгчтэй хамтран ажиллахыг хүссэн юм.

### Сайн Зарчмыг Хэтрүүлэхийн Уршиг

Арваад жилийн өмнө би “Хүчирхэг Талууд Маань Бидний Сул Тал Болж ч Магад” гэдэг сэдвээр ярьсан. (*Ensign*, 10 сар. 1994, 11–19). Бид нэг сайн зарчмыг болон зарлигийг хэтрүүлэн дагахад юу болдог талаар би ярьж 20 жишээгээр иш татсан. Захирагч Стивенсоны хэлснээр “сэтгэл хөдөллөөр гэнэтийн хэтрүүлсэн зүтгэл” биш харин амьдралынхаа туршид тууштай, тогтмол хичээх гэсэн өнөөдрийнхөө уриалгадаа 5-ыг нь хэрэглэе.

Эхний жишээ маань эх оронч үзлийн тухай байг. Эх орноо хайрлах нь хэтэрвэл бидний сүнсэнд халтай байж болно. Зарим иргэдийн эх оронч үзэл (өөрсдийнх нь тодорхойлсноор) нь тэдний гэр бүл, сүм гэх мэтийн бусад хариуцлагуудыг нь давамгайлахаар хэтэрсэн байдаг. Жишээлбэл, байлдаанд хувиараа бэлдэж, эсвэл хувийн армид элссэн эх оронч гэгч хүмүүсийн тухай сонсогддог. Тэд эх оронч хэмээх нэг тал руу дэндүү хазайснаар Сүмээс холдон, итгэлийн тунхагийн дагуу бидний захирагдах ёстой улсын удирдагч нараас өөрсдийгөө тусгаарлан сүнсээ хохироодог.

Миний хоёр дахь жишээ нь Есүс Христийн тодорхой нэг зарлигт л өөрсдийгөө бүрэн зориулдаг хүмүүсийн тухай юм. Энэ нь гэр бүлийн түүхийн ажилд хэт төвлөрөх, эсвэл үндсэн хууль, засгийн газрын талаар ер

бусаар бодлогшрох мөн өөр ямар нэгэн зүйлд хэт их санаа тавих байж болно.

1971 оны Аравдугаар сарын ерөнхий чуулганаар өгсөн мртагдашгүй яриандаа Ахлагч Бойд К.Пакер сайн мэдээний бүрэн дүүрнийг төгөлдөр хуурын даруулуудтай зүйрлэсэн. Хүмүүс “нэг л товчлуурт татагдаж болно” өөрөөр хэлбэл “дахин дахин тоглогдсон” зарчмыг сонсохыг хүсдгийг тэрээр бидэнд сануулаад цааш нь тайлбарлахдаа:

“Арай илүүг мэдмээр зарим гишүүд дуртай нэг, хоёр товчлуурыг сонгож аваад тасралтгүйгээр дуугаргадаг. . . . Тэд сайн мэдээний бүрэн дүүрэн байдлыг умартан, дуртай нотоо сонгохыг илүүд үздэг. Ийнхүү энэ нь хэтэрч мөн мушгигдаад тэднийг урвалт тийш хөтөлдөг.” (*Teach Ye Diligently* [1975], 44).

Их Эзэн Шейкер бүлгийн гишүүдийн талаар хэлсэн шиг, “Тэд нар үнэнийг бүхлээр нь биш, зөвхөн нэг хэсгийг нь л мэдэх хүсэлтэй байдаг” (С ба Г 49:2) хэмээн эдгээр хүмүүсийг ч хэлж болно. Иймээс дуртай товчлууртай байхаас болгоомжил. Хэрэв нэг л товчлуурыг дарснаар сайн мэдээний бүрэн төгс аялгууг эвдвэл, та амьдралынхаа туршид тууштай болоод тогтмолоор хичээхээсээ гажуудаж байгаа хэрэг билээ.

Сайн зарчмыг хэтрүүлэн хэрэгжүүлэхийн уршигтайн талаарх эдгээр жишээг хэлэх зуураа би өөрийн дутагдлын нэгийг хүлээх ёстой. “Шинийг туршихад анхных нь биш бай, хуучныгаа орхиход сүүлчийнх нь биш бай.” гэх хуучны хэллэгийг та нар сонссон байх. Өнөө үеийн компьютер гэх мэтийн технологийн гайхамшгийн тал дээр, хуучныгаа орхих сүүлчийнх нь би байх гэж бодож байна.

Учир нь би одоо ч гар бичгийн машин хэрэглэдэг. Тавь гаруй жилийн турш би үе үеийн бичгийн машинуудын тусламжтайгаар яриануудаа бэлдэж, захиа, бичээсүүдийг бичиж ирсэн. Хэдэн жилийн өмнө түшиж тулдаг, хуучин ганц машин маань ажиллахаа больсон юм. Шинэ машины эрэл маань амархан биш байв.

Гар бичгийн машины дараа цахилгаан бичгийн машины технологийн үе гарч ирсэн. Харин би тэр үеийг алгассан. Дараа нь миний нарийн бичиг Маржи МакНайтийн энэ ярианы маань олон хувилбарыг бэлдэхдээ хэрэглэсэн шиг нарийн чадалтай компьютер гэгч гарч ирсэн. Дэлгүүрт одоо үүнийг л зардаг болсон тул жижиг гар бичгийн машин асуухад минь залуу худалдагч үг дуугүй ширтэн зогсохыг хараад гайхах хэрэггүй байсан биз. Нэг залгуураас нөгөөд

залгахаар бариад явж болох авсаархан цахилгаан бичгийн машиныг нэг хүн олоод миний хайж байгаа зүйл мөн эсэхийг асуусан юм.

Эцэст нь, зөөврийн гар бичгийн машин гэж юу болохыг мэддэг буурал үстэй эзэнтэй нэгэн жижгхэн дэлгүүрийг би оллоо. Тэр ч бүү хэл түүний арын агуулахад нь нэг байсан ба би ч баяртай нь аргагүй худалдан авч билээ. Эзэн нь миний үүгээр юу хийх гэж байгаа талаар сонирхож байв. Тэрээр дэндүү зөлдөгхэнээр таамаглан асуусан юм. Шинэ бичгийн машиныг минь надад өгөнгөө тэрээр, “Эдгээр нь нэг их зарагдаад байдаггүй юм. Та зэлүүд газраар их аялдаг байж таарна.” гэж билээ.

Би сэтгэлийн хөдөллөөр гэнэтийн хэтрүүлсэн зүтгэл болон тууштайгаар хичээх хоёрын хоорондох ялгааны гурав дахь жишээгээ авья. Өөрийн эзэмших бүхнээ Их Эзэний ажилд золиослоход бэлэн байх нь яах аргагүй амьдралаа зориулсан гэсний тэмдэг юм. Үнэндээ энэ бол бидний нандин газарт хийдэг гэрээ билээ. Гэхдээ энэ нь Их Эзэн болон түүний удирдагчдын тухайн үед биднээс шаардсан золиослолд хамаатай байна. Бид Алматай санал нийлэн “Өөрийнхөө дуудагдсан тэр ажлыг гүйцэтгэхээс илүүг би яагаад хүсэх билээ?” хэмээх ёстой. (Алма 29:6) Аравны нэг, мацаг барилтын өргөлөө өгөх, томилогдсон дуудлага хийх нь хангалттай биш хэмээн үздэг тэдгээр нь золиослох хүслээсээ үүдэн хэт ихээр золиослуулах урсгал бүлгийн буруу замаар хөтлөгдөх нь амархан байдаг. Энэ нь миний яриад байгаа “гэнэтийн хэтрүүлэг” юм.

Дөрөв дэх жишээ нь зорилгын тухай юм. Өөрсдийн зорилгодоо анхаарлаа төвлөрүүлснээр хүчийг олж болдог. Бид бүгд л үүний үр жимснээс хүртэгчид. Гэсэн ч зорилго дээрээ хэт их анхаарал хандуулснаар хүн зохистой *арга* гэж юу болохыг умартаж болох юм. Ингэснээр магтууштай, тууштай чармайлт нь уршигтай гэнэтийн хэтрүүлэг болон хувирч болно

Гэнэтийн хэтрүүлсэн зүтгэлээс зайлсхийн, тууштай хичээх хэрэгтэйн тав дахь жишээ нь санхүүгийн талаар юм. Бид ядуустай хуваалцахаар зарлигдуулсан билээ. Энэхүү Христийн үндсэн үүргийг хэтрүүлэн биелүүлнэ гэж байх уу? Тийм ээ болох юм. Би үүнийг харсан. Өөрсдийнх нь гэр бүлд хэрэгтэй цаг хугацаа, эд хөрөнгийг ядууст өгөх үүргийнхээ дагуу хэтрүүлэн зарснаар гэр бүлээ ядууруулсан хүмүүсийг та нар ч харсан байж болох юм.

Хуучны үгээр бол бид тарианыхаа үрийг идчихэж болохгүй. Ингэсэн тохиолдолд бид дараа жилдээ үр

тарьж, ургац хураан гэр бүлээ тэжээж мөн ядууст өгөх боломжгүй үлдэнэ. Өөрийн хүмүүсийн өлссөнийг хооллож, нүцгэнийг хувцаслан, өвчтэйг эргэн, асрахыг зарлиглаж (Мозая 4:26 үз) Бэнжамин хаан хүмүүстээ хандан “эдгээр зүйлүүд мэргэн ухаанд мөн эмх замбараанд хийгдсэн болохыг мэдэгтүн, учир нь хүн өөрт буй хүчнээс илүү хурдан гүйх нь шаардлагатай биш юм” хэмээн сануулсан. (ш.27; С ба Г 10:4 үз)

Эдгээр таван жишээгээ дуусгахын ялдамд нэгэн сэрэмжлүүлгийг бас хөндөх хэрэгтэй байна. Гэнэтийн хэтрүүлгээс зайлсхийж, тууштайгаар хичээхийн зарчим нь бүх зүйлд дунд хэмжээнд байх ёстой хэмээн ойлгогдож болох юм. Гэхдээ тийм биш. Аврагч маань биднийг бүх “зүрх сэтгэл, хүч чадал, оюун ухаанаар” үйлчлэн (С ба Г 4:2), “мөнхийн баялгийг хичээнгүйлэн эрэлхийлж” (С ба Г 68:31), мөн “Есүсийн гэрчлэлдээ үнэнч бай” (С ба Г 76:79) хэмээн зарлигласан. Хэрэв бид бүлээн бол Тэр биднийг амнаасаа гаргаж хаях болно гэсэн байдаг. (Илчлэлт 3:16 үз) Жишээнүүдийн маань гол санаа нь, бид өөрсдийн зориулалт, амлалт болон чармайлтдаа гуйвшгүй бөгөөд тууштай байх ёстой гэдэг нь юм.

## Болзоо ба Нийлж Явахын Ялгаа

Амьдралын туршид тууштайгаар хичээхийн чухлыг болон зарчмуудыг хэтрүүлэхийн уршгийг үзүүлэхийн тулд би хэдэн жишээ татаж үзлээ. Хэрэв би та нарыг энэ тал дээр өөрсөд дээрээ дүгнэлт хийхийг ухуулахдаа амжилт олоогүй бол сүүлчийн сэдэв маань харин чадах байх.

Хоёр долоо хоногийн өмнө Бригам Янгийн Их Сургуулийн төгсөлтийн үеэр өгсөн яриандаа Ахлагч Өрл С.Тингий та нарын насны залуучуудын талаар *Тайм* сэтгүүлийн саяхны нэг дугаарт хэвлэгдсэн өгүүлээс иш татсан билээ. Үүнд тэрээр 18–25 насныхны үеийг “тусгай, тусгаарлагдмал амьдралын үе шат, идэр наснаас насанд хүрэгчдэд шилжих өвөрмөц үе мөн зарим нь илүү хэдэн жилийг насанд хүрэгчийн хариуцлагыг хойшлуулах замаар өнгөрөөх болсон” хэмээн хэлсэн байв. (Lev Grossman, “Grow Up? Not So Fast,” *Time*, 1 сар. 24, 2005, 44). Энэ өгүүлэл нь шилжилтийн насны эдгээр хүмүүсийг “байнгын идэр насныхан, . . . хорин хэдтэй Петер Панчууд” хэмээн дүрсэлсэн. (х.42) Энэхүү жишээгээ тэрээр БЯИС-ийн төгсөгчид болон тэдний гэр бүлийхэнд илүү хандуулан, “зарим төгсөгчид . . . гэр бүл болон гэрлэлтийн хариуцлагыг хүлээх талаар эргэлздэг” тухай ярьсан. (нээлтийн үг, 4 сар. 21, 2005)

Гэрлэлт, гэр бүл гэх мэт насанд хүрэгчдийн хариуцлагыг хойшлуулах тал үнэндээ манай ХҮГ залуучуудын дунд харагдаж байна. Сүүлийн цөөн хэдэн арван жилд гэрлэлтийн дундаж нас нэмэгдэн, ХҮГ гэр бүлээс төрж буй хүүхдүүдийн тоо цөөрч байна. Гурван сарын өмнө Ахлагч Нелсоны өгсөн *Итгэл ба Гэр бүл* гэсэн сэдэвтэй яриа энэ талаар байсан бөгөөд энэ нь түүнчлэн миний “Амьдралынхаа Туршид Хичээх нь” гэсэн сэдвийн маань нэг хэсэг юм. Иймээс надад хойд Америк дахь ХҮГ ганц бие залуучуудын хоорондох харилцаанд тохиож буй явдалд санаа зовж байгаа хэдэн зүйл байгаагаа илэрхийлье.

Мэдлэг бүхий ажиглагчид их сургуулиуд дээр болон залуу эрэгтэй эмэгтэйчүүдийн дунд болзох гэдэг нь ерөнхийдөө байхгүй болоод байгааг мэдээлжээ. Энэ нь “нийлэх” гэгч нэр томъёогоор солигдсон байна. (Bruce A. Chadwick, “Hanging Out, Hooking Up, and Celestial Marriage,” *Brigham Young University 2002–2003 Speeches* [2003], 1–8 үз) Та нар энэ юу болохыг мэдэж байгаа. Гэвч дунд болон үүнээс ахмад насны эсвэл үүнийг мэдэхгүй тэдгээрт би тодорхойлж өгье. Нийлэх гэгч нь хэд хэдэн охид, залуус хамтдаа нийлэн ямар нэг үйл ажиллагаа хийхийг хэлдэг. Энэ нь болзооноос огт өөр юм.

Дунд ба үүнээс ахмад насны бус тэдгээрийн заримын төлөө би болзоо гэж юу болохыг бас тодорхойлох хэрэгтэй байж болох юм. Нийлэхтэй адилгүйгээр болзоо гэдэг нь ямар нэг багийн спорт биш. Энэ нь хоёр хүн нүүр нүүрээ тулан танилцаад гэрлэлтэнд хүргэж болох түр зуурын харилцаанд орохыг хэлдэг.

Чухам юу болзоог ховор зүйл болгочих воо? Сайн мэдэхгүй л юм. Гэхдээ юу нөлөөлж болохыг хэлбэл:

1. Дэлхийн өнөөгийн байдал гэр бүлийн амлалтын эсрэг хүчтэйгээр сөрөн явж байна. Жишээлбэл, хуулийн дагуу салах нь амархаг болж, хүүхэд төрүүлэх нь ховорджээ. Энэ байдал нь Эцэгийн хүүхдүүдийнхээ төлөө гаргасан төлөвлөгөөний эсрэг байх чөтгөрийн төлөвлөгөөг дэмждэг нь илэрхий. Энэхүү төлөвлөгөө нь гэрээнүүд болон амлалтаа биелүүлэх дээр тогтдог. Биднийг амлалтаа биелүүлэхээс холдуулдаг хүчин зүйлс болгон нь уг төлөвлөгөөнд оролцох чадварыг маань багасгадаг. Болзоо нь хэдхэн цагийн турш ч гэсэн амлалтыг шаарддаг. Харин нийлж явах нь ямар ч амлалтыг шаарддаггүй ба ялангуяа эмэгтэйчүүд нь хоол байраар хангаж байгаа тохиолдолд эрэгтэйчүүдээс бол бүр ч үгүй.

2. Эмэгтэйчүүдийн эрэгтэйчүүдтэй ижил түвшинд байгаа нь болзохыг багасгах хүчин зүйл болжээ. Эмэгтэйчүүдийн боломжууд нэмэгдэн, зарим нь илүү биеэ даасан болсны зэрэгцээ, тэднийг дорд үздэг гэж ташаа ойлголт төрүүлэхгүйн тулд зарим эрэгтэйчүүд болзоонд урих гэх мэт угийн эрэгтэй хүнийхээ үүргүүдийг хүлээхээс дургүйцэх болж.
3. Ганц бие хүмүүсийн талаар телевизийн хөтөлбөрүүд дээр нийлж цаг нөгцөөхийг их гоёор харуулдаг.
4. Болзооны утга учир, ач холбогдол нь өөрчлөгдөж, болзоонд явахад үнэ шаардагддаг болжээ. Өсвөр насны хүүхдүүдийн маань дунд энэ байдлыг би ажигласан. Ямар нэг шалтгаанаар ахлах сургуулийн хөвгүүд охидыг болзоонд, ялангуяа төгсөлтийн үдэшлэг гэх мэт онцгой үйл явдалд урихын тулд ямар нэг онцгой, үнэ бүхий зүйлийг хийх ёстой гэж боддог болсон бөгөөд охид ч урилгыг нь хүлээн зөвшөөрөхдөө мөн л нэг онцгой, үнэтэй зүйл хийх ёстой гэж боддог болжээ. Түүнчлэн болзоо нь ямар нэг үнэтэй бүтээгдэхүүн мэт. Далаад оны үед БЯИС-ийн талбайд нэг иймэрхүү зүйл харагдсан. БЯИС-ийн хөл бөмбөгийн талбайн урд хэсэгт суусан нэгэн хос найзуудаараа үдийн хоол авчруулаад идэж байсныг би санаж байна.

Энэ бүхнээс болж болзох нь илүү хүндрэлтэй байдаг болж. Урилга нь сүртэй болзоо нь үнэтэй болох тусам болзоо нь ховордоод байна. Тэрчлэн болзоо нь сүржин бас ховор болох тусам энэ нь дотно харилцаа болон үргэлжилсэн амлалтыг бий болгох гээд байгаа мэт санагдах болсон юм шиг. Энэ нь болзоог бүр л ховордуулна. Аав ээж, өвөө эмээгийн чинь үеийнхний жирийн, хямдхан урилга болох утсаар яриад урина гэдэг нь алга болжээ. Нэг иймэрхүү маягаар ярьдаг байв. “Чи өнөө орой юу хийх гэж байна? Хоёулаа кинонд явах уу?” эсвэл, “Хотын төвөөр хамтдаа алхах уу?” Ийм хямдхан болзоо нь байнгынх байж болох ба үргэлжлүүлсэн амлалт хийх шаардлаггүй тул сүрдмээр биш юм.

Энгийн болон олон тохиодог болзоо нь эрэгтэй, эмэгтэй хоёрт аль алинд нь хүрээгээ илүү тэлж, бусдыг илүү таньж мэдэх боломжийг өгдөг. Хуучин цагийн болзоо нь эсрэг хүйстнийхээ хүнийг мэдэж болох нэгэн сайхан боломж байлаа. Энэ нь харилцан яриаг дэмждэг ба нүүр тулсан байдалд бусадтай хэрхэн харьцдаг, мөн бусад хүмүүс өөртэй чинь хэрхэн харьцаж байгааг ажиглах боломж өгөх болно. Энэ

дотно харьцааг хэрхэн эхэлж, үргэлжлүүлэхийг сурах боломжийг бас өгдөг. Эдгээрийн аль нь ч олуулаа нийлж цаг нөгцөөхөд тохиолддоггүй.

Ганц бие ах, эгч нар минь, энгийн болзооны загварыг дагацгаа, интернэтийн чатаас болон хосыг олж өгдөг үйлчилгээ хийдэг газраас хүнээ хайх хэрэггүй. Энэ нь уршигтай байж болох ба адаглаад шаардлаггүй, үр дүнгүй юм.

Болзох нь цөөрч, олуул нийлэн явахад нөлөөлж буй бас нэгэн хүчин зүйл байна. Олон жилийн турш Сүм 16 нас хүрэхээс өмнө болзоонд явахгүй байхыг өсвөр насныханд зөвлөсөөр ирсэн. Магадгүй зарим нь, ялангуяа эрэгтэйчүүд энэ мэргэн зөвлөгөөг хэтрүүлэн, 26, бүр 36 хүртлээ болзохгүй байхаар шийдсэн бололтой.

Эрэгтэйчүүд ээ, хэрэв та нар номлолоосоо бууж ирчихээд, 15 настайдаа дагахыг заалгаж байсан охин, хөвгүүний харьцааг дагасаар байгаа бол одоо өсөх цаг чинь болжээ. Зоригоо чангалаад хос болох хэн нэгэнийг хай. Олон охидтой, олон болзоонд явж эхлэн, тэр дундаас таарах нэгэнтэй дотносож эхэл. Энэ нь гэрлэх цаг ба Их Эзэн залуу охид, хөвгүүддээ үүнийг хүсдэг юм. Эрэгтэй хүмүүс эхлүүлэх үүрэгтэй бөгөөд залуус та нар одооноос үүнийг хийж биелүүлж эхэл. Болзоо гэж юу болохыг хэрэв та нар мэдэхгүй бол дараах тодорхойлолт тусалж магадгүй юм. Би үүнийг 18 настай ач охиноосоо сонссон юм. “Болзоо” нь дараах 3 шалгуурыг давах ёстой үүнд: (1) урьдчилан төлөвлөгдсөн, (2) нөхцөл бүрдсэн, (3) хоёроор хосолсон.

Залуу эмэгтэйчүүд ээ, хэт их нийлэн цаг нөгцөөхөөс зайлсхий, энгийн, хямд, болон олон удаагийн болзоог дэмж. Эмэгтэйчүүд та нар өөрсдөө хоолыг нь бэлдэж өгөөд, залуусыг олноороо нийлэн цаг нөгцөөхийг бүү дэмж. Ашиглагч нарыг битгий хоолло. Үе үе олноороо нийлэн цагийг өнгөрөөх нь зүгээр л дээ гэхдээ үүнийг эсрэг хүйстнийхэнтэйгээ харьцах гол харьцаа болгож байгаа залуусыг та нар харвал хоол хүнсээ цааш тавин, хаалгаа түгжиж байх нь дээр гэж би бодож байна.

Хэрэв ингэхээр шийдвэл хаалган дээрээ “Болзоонд явах боломжтой” гэсэн тэмдгийг ч бас өлгөсөн нь дээр. Залуу эмэгтэйчүүд минь, эдгээр ичимхий залуус та нарыг энгийн, хямдхан болзоонд урихад нь боломжийг олгоорой. Ингэхийн тулд болзоо гэдэг нь заавал дотносох зорилготой гэсэн бодлоос зайлсхийх хэрэгтэй юм. Хэрэв бид залуусыг илүү

олон дахин болзоонд урьдаг болгомоор байвал, болзоо гэдэг нь үргэлжилсэн амлалтыг шаардах шаардлаггүй юмаа гэдгийг хоёр талаасаа ойлгох хэрэгтэй. Эцэст нь охидууд минь, хэрэв болзоонд явахад татгалзаж байгаа бол үүнийг найрсаар хэлээрэй. Тэгэхгүй аваас ичимхий, сандарсан гуйгчийг няцаан, цаашид болзоонд асуудаггүй нэгэн болгочих вий. Энэ нь өөр хэн нэгэн охиныг хохироож болох юм.

Ганц бие залуу найз нар минь, эсрэг хүйстнийхэнтэйгээ харилцах харилцаагаа хөл бөмбөг гэх мэт ширүүн спортыг л номхотгож чадах нийлэн цаг нөгцөөхөд биш харин гэрлэлтэд хөтлөх болзооны загварт шилжүүлээрэй. Гэрлэлт нь хүүхдүүдийг гарч иртэл л лав бүлгийн харилцаа биш байдаг.

Эгч нар аа, ганц бие залуусын хариуцлагын талаар голлон ярьсан маань та нарт таалагдсан шиг байна. Одоо тэгвэл та нарын талаар хэдэн үг хэлье.

Хэрэв та нар гэрлэж болох нэгэнийг хүлээгээд л цагийг өнгөрөөж байгаа бол үүнийг зогсоогоорой. Та нарт энэ амьдралд гэрлэх боломж олдохгүй ч байж болох иймд хүлээхээ болиод, урагшил. Боловсрол, туршлага, төлөвлөгөөтэйгөө өөрийгөө амьдралд, бүр ганц бие хүний амьдралд ч хамаагүй бэлтгээрэй. Аз жаргал дээрээ чинь буун ирэхийг бүү хүлээ. Үйлчлэл болон сургалтаар үүнийг эрж хай. Өөрийнхөө төлөө амьдралыг босго. Их Эзэнд найд. Амьдралын туршид гаргах хичээл зүтгэл чинь Бэнжамин хааны “Их Эзэний нэрийг өдөр тутам дуудан . . . тэр ирэх зүйлд итгэх сүсэг бишрэлд гуйвшгүйгээр зогс” хэмээх сургамжийн дагуу байх ёстой. (Мозая 4:11)

### “Тэд Өөрсдийгөө Захирдаг”

Эгч нар аа, одоо би нэгэн туршлагатанг та нарын өмнө урья. Энэ бол миний эхнэр Кристен. Бид гэрлэхээс өмнө тэрээр 35 жилийг ганц бие насанд хүрэгчийн амьдралаар туулсан юм. Би түүнийг бидний өмнө гарч ирж, зүрхнийхээ үгнээс хуваалцаач хэмээн урьж байна.

**Кристен Өүкс эгч:** Ахлагч Өүкст баярлалаа. Би тавь гараад хүнтэй гэрлэсэн бөгөөд яг л “хөгшин” охины үлгэр жишээ болж буй мэт санагдаж байна. Юуны түрүүнд Тэнгэрлэг Эцэг чинь та нарт ямар их хайртай билээ гэдгийг би хэлэхийг их хүсэж байна. Бид Оукландад байгаа ба эндээс зам гараад байдаг айлчлагчдын төв рүү номлолын Ерөнхийлөгч Роберт Бюмантай миний бие хамт явсан юм. Христийн

хөшөө болоод Амьд Христ тунхагийг хараад зүрх минь дүүрч билээ. Энэ бол та нарын цаг. Үүнийг үр дүнтэй болгохын тулд Тэнгэрлэг Эцэгтээ зориул.

Цагаатгалын талаар Ерөнхийлөгч Пакерийн хэлсэнд би их дуртай. Цагаатгал гэдэг нь амьдралын маань эцэст л хэрэг болдог зүйл биш. Энэ нь бидний өдөр тутмын амьдралд тохиож байдаг. Үүнийг би ганц бие эгч нартаа хандаж хэлж байна. Үүнийг үр дүнтэй болго.

Сүмийн гэр бүлүүдийн дунд удаан хугацаагаар ганц бие явна гэдэг бол үнэхээр хэцүү асуудал. Энэ ямар байдгийг би мэднэ. Тавин насны минь төрсөн өдрөөр хадам ах маань нэг сонин уншиж байгаад надад “Энэ сонинд хэлснээр бол халдлаганд өртөн амь алдах боломж чинь 50 насандаа гэрлэх боломжоос чинь илүү байдаг юм байна” гэж хэлж байсан юм. Түүнийг ингэж хэлэхэд болзоо хийх нь хэцүү гэдгийг би мэдэж байсан. Ядаж л энэ нь дайран халдах үйл ажиллагаа биш болохоор би бууж өгөөгүй юм.

Би түүнчлэн та нарт тогтвортой бай гэж хэлмээр байна. Ганц бие эмэгтэйн хувьд урагшилсаар байх хэрэгтэй байлаа. Доктрант зэрэг авч ажилдаа нэндүү их цагийг зарснаар би сайн хүн байхаа мартсан байв. Энд сууж буй бүх хүнд хандан, та нарын нэн тэргүүнд тавих дуудлага чинь эцэг, эх байх явдал юм гэдгийг үргэлж санаарай гэж хэлэх ёстой санагдана. Дотоод авъяас болох хайр, үйлчлэлээ хөгжүүл. Ганцаараа байхдаа эдгээрийг би хайж олох хэрэгтэй болдог байлаа. Харин одоо бол орой болгон гал тогооны өрөөнөөс үүнийг олох боломжтой болсон юм. Би үүнд хязгааргүй талархдаг.

Бидний амьдралын хүнд цагууд надад бодогдож байна. Гэр бүлтэй ч бай ганц бие ч бай энэ нь тохиолдох л зүйл. Хүүхэд чинь хүнд өвчтэй юмуу эсвэл дотно нэгэний чинь үхэл хагацал, мөн ганцаардал амьдралыг чинь ноёлох мэт санагдаж болно. Хүүхдээ алдаж, өөрийн зүгээс юу ч хийж чадахгүй өвчин эмгэгт автаж болно. Гэвч би та нарыг Тэнгэрлэг Эцэгтээ төвлөрхийг гуйж байна. Хиламан 3:35-д хэрэв бид зүрх сэтгэлээ Бурханд зориулбал бидний бүх үйлдэл биднийг ариусгаж, бүх л цагт адислагдах болно гэсэн байдаг.

Та нар бол энэ дэлхий дээрх миний хайртай хүмүүс юм. Та нар надад их дотно санагддаг. Учир нь би та нарын оронд байх ямар байдгийг мэддэг ба ингэж удаан хугацаагаар явсан юм.

Энэ бол амьд Бурханы Сүм, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм гэдгийг би мэднэ. Үнэхээр Түүний сүм юм. Бидэнд амьд бошигогч Гордон

Б.Хинкли байгаад би гүнээ талархаж байна. Бүхнээс илүүгээр би хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэг байдгийг мэднэ. Намайг хайрлах хэнч үгүй үед тэр миний хамгийн сайн найз минь болж байсан юм. Үүнийг би Есүс Христийн нэрээр хэллээ, амэн.

**Ахлагч Даллин Х.Өүкс:** Кристенд баярлалаа. Ах эгч нар минь, бидний хэлсэн ямар нэг зүйл санааг тань зовоосон бол одоо миний хэлэхийг анхааралтай сонсоорой. Магадгүй та гэрлэлтэнд хүргэж болох болзооны эхлэлийг тавих хэрэгтэй хэмээн миний хэлсэнд санаа зовсон залуу эрэгтэй, эсвэл амьдралдаа урагшлах хэрэгтэйн талаар хэлсэн зүйлд сэтгэл түгшсэн залуу эмэгтэй байж болох юм.

Хэрэв өөрт чинь энэ зөвлөгөөнүүд онцгой шалтгаанаар хамаарахгүй гэж үзэж байгаа бол надад захиа битгий бичээрэй. Яагаад би ийн гуйж байгаа вэ? Иймэрхүү зөвлөгөөнүүдийн маань учир өөрсдийн онцгой нөхцөл байдлаа тайлбарлан, үүнд нь тэдгээр зөвлөгөөнүүд хамаарахгүй гэдгийг надаар баталгаажуулахыг хүссэн олон тооны захиаг би гишүүдээс авах болсон юм.

Би ийм захианд яагаад хангалттай тайвшралыг хариу болгон өгч чаддаггүйгээ тайлбарлахын тулд ерөнхий тушаалд санаа нь зовнисон нэгэн хүний талаар хуваалцаж. “Хүн бүү ал” (Египетээс гарсан нь 20:13) гэсэн зарлигийг дурдсан нэг яриаг би өгсөн юм. Дараа нь нэг хүн над дээр уйлж ирээд өөрт нь ямар ч найдлага байхгүй хэмээв. “Юу гэсэн үг вэ?” хэмээн би асуулаа.

Тайлбар нь, тэрээр Солонгосын дайны үед автомат бууч байсан ба дайсны талын дайралтын үеэр түүний буу хүний амийг олноор нь устгаж байж. Цогцсууд дэндүү өндөрт овоорсон байсан тул дахин галлаж болохын тул холдуулах шаардлагатай болж байжээ. Тэрээр зуу гаран хүнийг алсан ба дээрх тушаалын талаар миний ярьсныг сонссон учир там руу явах нь зайлшгүй болсон гэж бодсон байв.

Миний хэлсэн та нарт хамаарахгүй гэж үзэж байгаа бол тэр хүнд өгсөн хариултаа та нарт ч өгье. Ерөнхий эрх мэдэлтнийхээ хувьд ерөнхий зарчмыг заах нь миний үүрэг билээ. Ингэхдээ би хамаарахгүй байж болох бүхий л нөхцөл байдлыг тодорхойлохыг хичээдэггүй. Зарим дүрэмд хамааралгүй байж болох шалгаанууд бий. Жишээ нь, байлдаанд, хуулийн дагуу албадуулагдан алах нь зарлигийг зөрчиж байгаа хэрэг биш гэж бид итгэдэг. Гэсэн ч өөрийн нөхцөл дээр миний бодлыг эрэлхийлэхийн хэрэггүй. Би

ерөнхий зарчмуудыг л заадаг. Өөрийн тань байдалд хамаарах эсэхийг та нар өөрсдөө шийд. Үүнийг Их Эзэнтэй хувиараа шийдэх учиртай.

Бошиглогч Иосеф Смит адил зүйлийг арай өөр үгсээр хэлсэн юм. Хэн нэгэн түүнээс ийм олон янзын хүмүүсийг хэрхэн захирдаг талаар нь гайхан асуухад тэрээр: “Би тэдэнд зөв зарчмуудыг зааж харин тэд өөрсдийгөө захирдаг” гэжээ. (John Taylor, “The Organization of the Church,” *Millennial Star*, 11 сар. 15, 1851, 339). Энэхүү яриандаа би та нарт зөв зарчмыг заасан ба та бүхнийг өөрсдийгөө захирснаар эдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэхийг урьж байна.

Ах Эгч нар минь, та нартай хамт байх үнэхээр сайхан байлаа. Өнөөдрийн яригдсан зүйлс зүрх сэтгэлд чинь орж, Ариун Сүнсний хүчээр ойлгогдон, зүдэрснийг тайвшруулж, тайвширсныг зүдрээн, амьдралыг тань адислах болтугай хэмээ би залбирч байна.

Энэ бол Есүс Христийн Сүм. Бидэнд дахин амилах баталгаа болон мөнхийн амьдралыг хүртэх боломжийг өгөхийн тулд Тэрээр Гетсеманид мөн Калварид аймшигт зовлон эдлэн амиа өргөсөн билээ. Хараагаа өндөрсгөн, амьдралынхаа туршид тууштай, тогтмолоор хичээн өдөр бүрийн үүргээ гүйцэтгэ хэмээх Их Эзэний тушаалыг биелүүлэхийг эрэлхийлэхэд маань Их Эзэн бидний хүн нэг бүрийг адислах болтугай. Энэ бол Есүс Христийн Сүм, санваарийн хүчээр, сургаалийн бүрэн дүүрнийг тээсээр хожмын өдрүүдэд сэргээгдсэн билээ. Тийнхүү би өөрийн гэрчлэлээ хуваалцахын хажуугаар Их Эзэний адислалуудыг миний тэнгэрлэг найзууд та нарынхаа дээрээс бууж ирэхийг Есүс Христийн нэрээр гуйж байна, амэн.